БАТЛАВ

ХОВД АЙМГИЙН ЦЭЦЭГ

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Б.ОДОНБАЯР

# ЦЭЦЭГ СУМЫН ЭКО НОЙЛ БАРИХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023.05.30 ЦЭЦЭГНУУР

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Төсөл боловсруулах үндэслэл | | Ховд аймаг Цэцэг сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2023 оны 12 сарын 18-ны өдрийн 12/04 тоот тогтоолоор батлагдсан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, шинээр эхлэх хөрөнгө оруулалтын 3.10-д тусгагдсаныг үндэслэл болгоно. |
| 2 | Ажлын нэр төрөл /байршил/ | | Ховд аймаг Цэцэг сум Цэцэгнуур баг |
| 3 | Ажлын зориулалт | | Олон нийтийн зориулалтаар ажиллах |
| 4 | Төсвийн захиалагч | | Ховд аймаг Цэцэг сум ЗДТГ |
| 5 | Нийт хийх эко нойлын хэмжээ | | 12 |
| Ерөнхий үзүүлэлтүүд | | | |
| | Нэршил | Тоо ширхэг | Ерөнхий шаардлага |
| 6 | Жорлонгийн суурийн нүх ухах | | Ф1500 ултай кольцо 2ш, дунд таславч кольцо 2ш нийт 4ш. 5,6тн бохирыг хуримтлуулан татан зайлуулах хүчин чадалтай 4м гүнтэй жорлонгийн суурийн нүх ухна. |
| 7 | Жорлонгийн шалны бүтэц | | Шалны бүтэц нь 14шивлээр 12шивлээр нь 1,5-2,2мм зузаантай байх ба урд хойд хэсэгт нь 14шивлээр мөн 2,5м хэсэгт нь 5х10-ын 2,5-3мм зузаантай квадрат төмөр байна. Шалны доод бүтэц нь 6х2,5м алслалтай байх ба нийт приметр нь 17м байна. Шалны бүтэцийн 6м-ийг 1,2м-ээр хувааж 5х10-ын 1,8-2,2мм зузаантай квадрат төмрөөр бэхлэж хийх ба квадрат төмрүүдийн хоорондын 60см алслалтыг 4х4-ийн 1,5 мм зузаантай квадрат төмрөөр мөн гагнаж бэхлэнэ. Шалны материал дээр 1,2мм дээр 1,8мм зузаантай барилгын хулсан чийг бороонд тэсвэртэй хар панеран модыг дэвсэж өгөх ба дээр нь 1,2-1,5мм зузаантай хальтарч зэвэрдэггүй ган метал бүхий лист төмрөөр бэхлэж хийж өгнө |
| 8 | Жорлонгийн бүхээг хийх | 12 ширхэг | Бүхээгийн хаалга тал нь өндөр /230 см/, ар тал нь нам /210см/, хажуу талууд нь ижил өндөртэй байна. Хийгдэх жорлон нь 2 хүнийх байх ба 2метр X 1,2 метр хэмжээтэй байна |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | Агааржуулагч хоолой хийх /малгайвчтай/ | 8 ширхэг | 2,5 метр урт Ф100 хэмжээтэй PVC хоолойг бүхээгний 2 талд бэхлэж дээр нь зориулалтын малгайвч суурилуулна. |
| 10 | Бусад | | Суурийн нүхэн дэх ялгадсын хэмжээ нүхний амсраас доош 50 см-т хүрсэн суурийн нүхний эзлэхүүний 90 % нь ялгадас хөлдүүсээр дүүрсэн үед түүнийг соруулах буюу суллаж бохирыг холбогдох журмын дагуу зайлуулж, ариутгал хийж дахин ашиглана Улиралд 3-аас доошгүй удаа суурийн нүхийг суллах, бохирыг зайлуулах, ариутгах ажлыг гүйцэтгэвэл зохино. |
| 11 | Хийц, Бүтэц, Материал | | Нийт эзлэхүүн нь 15м2, дотор өндөр нь 2,5 метр. Дээвэр нь 35 градусын налуутай арк хэлбэртэй хоёр талын далавчнаасаа 2метр голдоо 3метр арк хийцтэй. Материал нь 2,3мм зузаан, бор энгийн матт равтар. Дээврийн дээд хэсгийн нугаралтын зайн 20см зайтай, дотор бүтэц хийцийг 4х4 квадрат төмрөөр хийн. Квадрат төмрийн зузаан 1,2мм-1,5мм зузаантай байх ба цахилгаан гагнуураар 1,6мм-9,8мм голчоор гагнасан байна. Гаднах нийт электродын хэмжээ нь 422,322 улаан бичигт электрод байна. Гадна дээврийн фасадын салхи нэвтрэх талыг цулгуй цагаан энгийн 1,2-1,5мм зузаантай дээврийн төмрөөр хийх ба 1см төмрийн өрмийн хошуут шрупээр хоорондох зайг 15см холгүй шрупдэж бэхэлсэн байна. Нийт арга бүтэц рам нь 6х2,5м өргөнтэй, өндөр нь 2,5 метр байхаар хийгдэх ба рам хоорондыг 5х10 зэвэрдэггүй ган цагаан энгийн 1,2-1,5мм квадрат төмрөөр гагнаж бэхэлнэ. Рамын босоо 4 тулгуур нь 2,5-3мм зузаан 5х10 квадрат төмөр байна. Квадрат төмрүүдийг нийт рамтайн гурвалжин дүрс маягаар дээд талд нь 6 доод талд нь 6 нийт урт нь 0,45см-ээр 95 градусын налуу үүсгэж бэхэлсэн байна. Ариун цэврийн байгууламжийн нийт босоо төмөрт нь 4х4, 5х5-ын 1,2-1,7мм зузаантай төмрүүдийг 1,2м зайтай дээд доод хэсгийг бэхэлж гагнаж өгсөн байна. Ариун цэврийн байгууламж нь 2 гэрэлтүүлэгтэй байх ба гэрэлтүүлэг нь урд хэсэгтэй 2м урттай, 60см өндөртэй байна. Урд цонх нь 80см өргөнтэй 1метр өндөртэй 0,66 рамын пластик вакум цонх байна. Гадна фасад нь термобазальт байх ба зузаан нь 1,2мм зузаантай сайн чанарын 38см өргөн бүхий хувилд орж тогтдог пластик материалаар бүрж өгнө. Дотор заслыг 40см өргөнтэй 1,8 мм зузаантай цагаан энгийн пластик хавтан байна. Дээврийн хэсэгт 1,2мм зузаантай хар панерийг 2,5см шрупээр тогтоон 6х2,5 уян таазыг хийж өгнө. Байгууламж дотроо гар угаалтуур 8ш, хурдны бойлер 4ш суурилуулсан байна. 4,6-9,8 метр паскал даралт үүсгэгч бүхий вакум коллектор хоолойгоор 1000л /нөөцийн/ усны саваар шахалт үүсгэж усан хангамжийг |

| | | | |
|---|---|---|---|
| | | | сайжруулна. Гадна талд 7 гэрэлтүүлэгтэй дотор талд 1,20 урттай 4ш гэрэлтүүлэг байна. Гэрэлтүүлгийн унтраалгыг гадна талд байрлуул[illegible] Хаалга нь 1,2x2,0 метр өндөртэй сайн чанарын вакум хаалга байна. |

ХЯНАСАН : ЗДТГ-ЫН ДАРГА Б.БИЛЭГТ

БОЛОВСРУУЛСАН : МТТНСА-ЫН АЖИЛТАН Г.ГАНЧӨДӨР